

UCS2023

ИЖ БҮРЭН ГУДАМЖ



Гудамжны төрөл ангилал, тавигдах шаардлага

ИЖ БҮРЭН ГУДАМЖ

Гудамжны төрөл ангилал,
тавигдах шаардлага



ГАРЧИГ

1. ЗОРИЛГО.....	5
2. ХАМРАХ ХҮРЭЭ.....	5
3. НОРМАТИВ ЭШЛЭЛ.....	5
4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
5. ИЖ БҮРЭН ГУДАМЖНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ.....	7
6. ХОТЫН ГУДАМЖНЫ ТӨРӨЛ АНГИЛАЛ.....	11
6.1. ХОТЫН ГОЛ ГУДАМЖ.....	13
6.2. ӨРГӨН ЧӨЛӨӨ БҮХИЙ ГУДАМЖ.....	14
6.3. ОЛОН ҮҮРЭГТ ГУДАМЖ.....	15
6.4. ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН ГУДАМЖ.....	16
6.5. ХУДАЛДАА АРИЛЖААНЫ ГУДАМЖ.....	17
6.6. СОЁЛЫН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ГУДАМЖ.....	19
6.7. ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ.....	20
6.8. ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ТӨВ ГУДАМЖ.....	21
6.9. ХОРООЛЛЫН ДОТООД ХОЛБООС ГУДАМЖ.....	22
6.10. ГЭР ХОРООЛЛЫН ТӨВ ГУДАМЖ.....	23
6.11. ГЭР ХОРООЛЛЫН ДОТООД ХОЛБООС ГУДАМЖ.....	24
6.12. НАРИЙН ГУДАМЖ.....	25
7. ШАЛГАХ ХУУДАС.....	27
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нэг цагт гудамжаар зорчих иргэдийн тоо. Эх сурвалж Global Design Guide	9
Зураг 2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тулгуурласан уламжлалт гудамж зам.....	10
Зураг 3. Иж бүрэн гудамжны зураглал.....	10
Зураг 4. Гудамжны төрөл ангиллыг тодорхойлох загвар	11
Зураг 5. Улаанбаатар хотын гудамжны төрлүүд	12
Зураг 6. Улаанбаатар хотын гудамжны төрлүүд жишээ зураглалтайгаар	12
Зураг 7. Хотын гол гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг.....	13
Зураг 8. Өргөн чөлөө бүхий гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	14
Зураг 9. Олон үүрэгт гудамжны эрэмбэ	15
Зураг 10. Олон үүрэгт гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг.....	16
Зураг 11. Үйлдвэр аж ахуйн гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	17
Зураг 12. Худалдаа арилжааны гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг.....	18
<i>Зураг 13. Цэцэрлэгт гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг.....</i>	<i>20</i>
Зураг 14. Орон сууцны хорооллын төв гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	21
Зураг 15. Хорооллын дотоод холбоос гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	22
Зураг 16. Гэр хорооллын дотоод холбоос гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	25
Зураг 17. Нарийн гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хотын гол гудамжны шалгах хуудас.....	27
Хүснэгт 2. Өргөн чөлөө бүхий гудамжны шалгах хуудас.....	27
Хүснэгт 3. Олон үүрэгт гудамжны шалгах хуудас.....	28
Хүснэгт 4. Аж үйлдвэрийн гудамжны шалгах хуудас.....	28
Хүснэгт 5. Худалдаа арилжааны гудамжны шалгах хуудас.....	28
Хүснэгт 6. Соёлын ач холбогдол бүхий гудамжны шалгах хуудас	29
Хүснэгт 7. Цэцэрлэгт гудамжны шалгах хуудас.....	30
Хүснэгт 8. Хөршлөл бүхий орон сууцны хорооллын төв гудамжны шалгах хуудас.....	30
Хүснэгт 9. Хорооллын дотоод холбоос гудамжны шалгах хуудас.....	30
Хүснэгт 10. Гэр хорооллын төв гудамжны шалгах хуудас	31
Хүснэгт 11. Гэр хорооллын дотоод холбоос гудамжны шалгах хуудас.....	31
Хүснэгт 12. Нарийн гудамжны шалгах хуудас	32

ИЖ БҮРЭН ГУДАМЖ

Гудамжны төрөл ангилал, тавигдах шаардлага

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь Улаанбаатар хотод үүсэн бий болсон олон хэв шинжийн гудамжны төрөл ангиллыг тодорхойлоход оршино.

Гудамжны төрөл ангиллыг тодорхойлсноор тухайн гудамжны хэв шинж, байрлал буюу газар ашиглалт хот төлөвлөлтийн бүсчлэлтэй нь уялдуулан гудамжны зураг төсөл боловсруулах төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Баримт бичиг нь нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, төлөвлөлт, бүтээн байгуулалтад загвар дизайн боловсруулах, өргөтгөн шинэчлэх, шинээр байгуулах, ашиглахад хамаарна.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан барилгын норм ба дүрэм, стандартыг хэрэглэнэ. Эш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

- Авто замын тухай хууль;
- Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө;
- БНБД 30-01-04, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 32-01-04, Хот суурины гудамж, зам төлөвлөлт;
- MNS 5025:2001, Авто үйлчилгээ. Ангилал;
- MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- MNS 4597:2014, Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4759:2014, Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 6808:2019, Явган хүний зам талбайн төлөвлөлт, Техникийн шаардлага;
- UCS0901B:2020, Явган хүний зам талбайн төлөвлөлт угсралтад тавигдах шаардлага;
- UCS0903B:2020, Унадаг дугуйн замын төлөвлөлт хучилтад тавигдах шаардлага;

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Авто зам – гэж тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу хучилттай гудамж, зам засаж сайжруулсан болон ердийн хөрсөн зам;

Гол зам - гэж замын хөдөлгөөний ачаалал өндөр, хөдөлгөөнд хөндлөнгөөс орох оролт хязгаарлагдмал авто зам;

Туслах зам /хуримтлуулагч зам/ - гэж замын техникийн эсвэл зориулалтын доод ангиллын замтай огтлолцож буй зам;

Унадаг дугуйн зам – гэж унадаг дугуй болон бусад моторгүй тээврийн хэрэгсэлд зориулагдсан аливаа байгууламж болох унадаг дугуйн эгнээ, унадаг дугуйн зам болон бусад байгууламж орно;

Унадаг дугуйтай зорчигч - гэж зорчих зорилгоор моторгүй, хүн хөдөлгөөний хүчээр явдаг дугуйтай тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа хүн (тэргэнцрээс бусад);

Унадаг дугуйн эгнээ – гэж унадаг дугуйн хөдөлгөөнд зориулан авто замыг зорчих хэсгийн гадна захаар байрладаг эгнээ. Унадаг дугуйн эгнээ нь тээврийн хөдөлгөөний урсгалын дагуу чиглэлд, нэг эгнээгээр явдаг;

Явган зорчигч – гэж гудамж замаар явган явж буй /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар явж буй болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирч, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар явж байгаа хүн;

Явган хүний зам – гэж зөвхөн явган зорчигчид ашиглах зориулалттай, авто зам болон бусад хэсгээс хашлагаар тусгаарлагдсан, явган хүн, харааны бэрхшээлтэй хүн, тэргэнцэртэй хүн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн явганаар зорчих чөлөөт зам талбай;

Замын хашлага - гэж автозамын захад байрладаг бетон хашлага;

Зорчих хэсэг – гэж авто тээврийн хэрэгсэл зорчиход зориулагдсан авто зам, замын байгууламжийн хэсэг;


Зорчих хэсгийн тусгай эгнээ - гэж нийтийн тээврийн хэрэгсэл болон яаралтай тусламж үйлчилгээний тээврийн хэрэгсэл зорчиход зориулсан авто замын зорчих хэсгийн эгнээ;

Цэцэрлэгт гудамж - гэж гудамж замын нийтийн эзэмшлийн талбайд байгуулсан ногоон байгууламж бүхий гудамж;

Тээврийн хэрэгслээр зорчигч - гэж тээврийн хэрэгсэл дээр буюу түүний бүхээг дотор байгаа жолоочоос бусад хүнийг. Тээврийн хэрэгсэл рүү орж байгаа болон түүнээс бууж байгаа хүнийг мөн хамааруулж ойлгоно;

5. ИЖ БҮРЭН ГУДАМЖНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Гудамж нь хот суурин газрын төлөвлөлтийн үндсэн элемент бөгөөд хотын орон зайн үндсэн нэгж юм. Гудамж нь авто зам, уулзвар, явган хүний зам, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, газар дээрх болон доорх дэд бүтэц /цэвэр усны шугам, цахилгаан, холбоо, үерийн усны шугам, бохир болон дулааны төв магистраль шугам, авто зогсоол/, ногоон байгууламж, гудамжны дизайн шийдэл гудамжны нэр унадаг дугуйн зам зэргээс бүрдэж иж бүрэн гудамжийг бүрдүүлдэг.



Гудамжны
төлөвлөлтийг
өөрчлөх

Унадаг
дугуйн замыг
дүй болгох

Явган хүний
замын гарц
хэсгийг
сайжруулах

Үр ашигтай
эрчим хүчний
хэрэглээг
дүй болгох

Нийтийн
тээврийн
хэрэгслийг
зохион
байгуулах



Явган хүний хөдөлгөөний сүлжээг дий болгох

Хурдны хязгаарыг тогтоох, аюулгүй байдлыг хангуулах

Унадаг дугуйн зогсоол, Нийтийн эзэмшлийн урлагийн бүтээлийг дий болгох


Мэдээллийн самбарууд дий болгох

Нийтийн эзэмшлийн талбайг идэвхжүүлэх, ААН-ийн үйл ажиллагааг дэмжих



5.1. Уламжлалт гудамж замын сүлжээ ба Иж бүрэн гудамжны ялгаа

Гудамж замын сүлжээний ангиллын систем нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг онцолж ангилсан байдаг. Энэхүү ангиллын систем нь хот суурин болон орон нутгийн авто замын зураг төслийн баримтлах баримт бичгийн үндэс суурь нь болдог ба автомашины тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүчин чадал давамгайлсан ашиглалтын шинж чанарт үндэслэсэн бөгөөд эгнээний өргөн, хурд, геометр, уулзварын зураг төсөл гэх мэт элементүүдийг төлөвлөхөд ашигладаг.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тулгуурласан гудамж




Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тулгуурласан гудамжны нэг цагт зорчих хүний тоо

	4,500/цаг	x2	9,000 хүн/цаг
	1,100/цаг	x3	3,300 хүн/цаг



Нийт зорчигчдын тоо:
- 12,300 хүн/цаг

Иж бүрэн гудамж



Хөдөлгөөнийг иж бүрнээр төлөвлөсөн гудамжны нэг цагт зорчих хүний тоо

	8,000/цаг	x2	16,000 хүн/цаг
	7,000/цаг	x1	7,000 хүн/цаг
	6,000/цаг	x1	6,000 хүн/цаг
	1,100/цаг	x1	1,100 хүн/цаг



Нийт зорчигчдын тоо:
- 30,100 хүн/цаг

Зураг 1. Нэг цагт гудамжаар зорчих иргэдийн тоо. Эх сурвалж Global Design Guide

Уламжлалт гудамж замын ангилал нь иж бүрэн гудамжны зураг төслийг гаргахад хангалтгүй юм. Иж бүрэн гудамжны зураг төслийг гаргахдаа хөрш зэргэлдээ орчны нөхцөл байдал, зэргэлдээ газар ашиглалтын төрөл, тухайн газрын онцлог болох түүхэн дурсгалт соёлын ач холбогдолтой газар зэргийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд эдгээр хүчин зүйл нь гудамж хэрхэн ашиглагдаж байгааг тодорхойлох чухал хүчин зүйл болдог. Гудамж замын ангиллын хүрээлэн буй орчны байршлаас хамаарч үүрэг зориулалт нь өөр өөр байна. Энэхүү ялгааг илүү сайн зохицуулж хотын оршин суугчдад гудамжийг өргөн хүрээнд ашиглахын тулд гудамжны төрөл ангиллын шинэ системийг бий болгосон.




Зураг 2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тулгуурласан уламжлалт гудамж зам



Зураг 3. Иж бүрэн гудамжны зураглал

6. ХОТЫН ГУДАМЖНЫ ТӨРӨЛ АНГИЛАЛ

Гудамжнууд нь өөр өөр төрлийн хэв шинж бүтэцтэй бөгөөд дизайны хувьд тухайн төрлийн гудамжиндаа тохирсон байх шаардлагатай. Гудамжны тохижилтыг шинэчлэн төлөвлөх, сайжруулахдаа тухайн гудамжны төрлийг тодорхойлж, түүндээ тохирсон төлөвлөлт хийх шаардлагатай.



Зураг 4. Гудамжны төрөл ангиллыг тодорхойлох загвар


Иж бүрэн гудамж бодлогын баримт бичиг нь Улаанбаатар хотод цаг хугацааны явцад үүсэн бий болсон. Гудамжны ялгаатай төрлүүдийг уламжлалт замын ангилал болон зэргэлдээх газар ашиглалт, гудамжны шинж чанар, гудамжны үйл ажиллагааны төрлүүдийн бодит байдлыг нэгтгэн Улаанбаатар хотын гудамжнуудыг үндсэн 12 төрөлд ангилсан.

Энэхүү ангилал нь:

- Улаанбаатар хотод байж болох бүх төрлийн гудамжны бүрэн жагсаалт биш боловч гудамжны зураг төсөл төлөвлөлт гаргах, одоо байгаа гудамжнуудын үйл ажиллагааг илүү сайжруулах арга замын эхлэл, үндсэн чиглэл болно.
- Шинэчлэн ангилсан гудамжны төрөл тус бүрд гудамжны тодорхойлолт, төлөвлөлтийн гол объектууд, тухайн төрлийн гудамжийг тохижуулж болох төлөвлөлтийн зураг (Зурагт тухайн төрлийн гудамжийг яг яаж төлөвлөх ёстойг нарийвчлан тусгаагүй болно), жишээ гудамж зэргийг багтаасан.
- Гудамжны онцлог шинж чанар, барилгын үүрэг зориулалтаас хамаарч нэг гудамж нь хэд хэдэн төрлийн гудамжны ангилалд хамрагдаж болно.
- Гудамжны төрлүүд нь гудамжны нийт уртын дагуу үргэлжлэх шаардлагагүй. Учир нь зэргэлдээх газар ашиглалт болон замын үүрэг зориулалтаас хамаарч гудамжны төрөл шинж чанар өөрчлөгдөж болно. Жишээ нь: Хөршлөлийн орон сууцны гудамжнаас Хөршлөлийн төв гудамж руу буцаад Хөршлөлийн орон сууцны гудамжнаас Худалдаа арилжааны гудамжийг дамжин өнгөрч болно.



Зураг 5. Улаанбаатар хотын гудамжны төрлүүд




Зураг 6. Улаанбаатар хотын гудамжны төрлүүд жишээ зураглалтайгаар

6.1. ХОТЫН ГОЛ ГУДАМЖ

6.1.1. Бүтэц

Хотын төвийн гол гудамжнууд нь хотын өндөр нягтралтай бүсэд байрладаг ба холимог ашиглалттай гудамжнууд юм. Тус гудамжнууд нь олон төрлийн газар ашиглалттай бөгөөд Улаанбаатар хотын олон нийтийн ажил хэргийн бүс болох хотын төвд томоохон оффисын зориулалттай барилга байгууламж болон төв гудамж дагуух оффисын зориулалттай барилга байгууламжууд, Банк санхүүгийн төвүүд, Засгийн газрын байрууд, Их сургуулиудын гудамж, орон сууцны хорооллууд, худалдаа үйлчилгээний томоохон их дэлгүүрүүд, ресторан, баар мөн жижиглэн худалдаа үйлчилгээний газрууд ч байршдаг. Эдгээр төрлийн гудамжнууд нь замын хөдөлгөөний ачаалал өндөртэй, дамжин өнгөрөх тэргүүлэх чиглэл, хотын хамгийн динамик олон нийтийн орон зайг бий болгодог.



Зураг 7. Хотын гол гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.1.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Явган хүний зам, өргөн чөлөө нь өргөн болоод өндөр чанартай байх мөн явганаар алхахад тааламжтай тав тухтай орчныг бүрдүүлсэн байх;
- Гудамжны элементүүд болох гадна талбайн зам талбайн саравч сүүдрэвч, сандал, мод ногоон байгууламжид хангалттай орон зайг бий болгохын тулд барилгын урд талбайг ашиглан тохижуулах;
- Явган зорчигчид, унадаг дугуйтай зорчигчид болон тээврийн хэрэгслүүдийг аюулгүй байдлын түвшнээр эрэмбэлэх мөн зорчих хурдаар нь төлөвлөх шаардлагатай;


- Гудамж замаар хөндлөн гарахад явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахын тулд гудамжны замын уулзварын тэмдэг тэмдэглэгээ нь товч тодорхой нүдэнд тусахууц төлөвлөгдсөн байх;
- Дугуйн зогсоол нь хүртээмжтэй байх ёстой ба дугуйн зогсоолыг ойролцоох нийтийн эзэмшлийн талбай, барилга байгууламжид нийцүүлэн төлөвлөх;
- Гудамж дахь модны өсөлтийн зай талбайг тооцож төлөвлөх;

6.2. ӨРГӨН ЧӨЛӨӨ БҮХИЙ ГУДАМЖ

6.2.1. Бүтэц

Энэ төрлийн гудамж нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн өндөртэй, олон төрлийн ашиглалттай байдаг. Мөн өргөн чөлөө нь өргөн хүрээтэй, гудамжнууд нь ногоон байгууламжтай, гудамжны элементүүдийг багтаасан явган хүний зам өргөнтэй гэх мэт хот байгуулалтын онцлог шинж чанаруудаар тодорхойлогддог. Улаанбаатар хот нь эдгээр гудамжны арвин баялаг өв ул амжлалтай бөгөөд Чингисийн өргөн чөлөө, Энхтайваны өргөн чөлөө нь хотын хамгийн том өргөн чөлөө юм.

Нягтшил өндөртэй бүсүүдийн замуудыг хуримтлуулан хөдөлгөөний ачаалалтай гудамжийг бий болгодог. Өргөн чөлөө бүхий гудамжнууд нь блокийн урттай байдаг учир ихэвчлэх уртын дагуу төлөвлөлт хийгдсэн. Гудамжнууд нь ихэвчлэн өндөр дунд давхрын барилга байгууламжтай.



Зураг 8. Өргөн чөлөө бүхий гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.2.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага




- Гудамжийг блокийн уртын дагуу төлөвлөвөл илүү зохимжтой;
- Явган зорчигч гудамжаар хөндлөн гарах боломжийг бүрдүүлж төв гудамж дагуу явган хүний замыг өргөтгөх, явган зорчигчдод зориулсан замын өргөтгөлийг төлөвлөх;

- Унадаг дугуйн зам, зогсоолуудыг стандартын дагуу өргөн бөгөөд чанартай төлөвлөх;
- Явган хүний зам, өргөн чөлөө нь өргөн болоод өндөр чанартай байх мөн явганаар алхахад тааламжтай тав тухтай орчныг бүрдүүлсэн байх;
- Гудамжны элементүүд болох гадна талбайн зам талбайн саравч сүүдрэвч, сандал, мод ногоон байгууламжид хангалттай орон зайг бий болгохын тулд барилгын урд талбайг ашиглан тохижуулах;
- Явган зорчигч, дугуйтай зорчигч, дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, моторт тээврийн хэрэгслийн дунд зэргийн хурдтай байхаар төлөвлөх;
- Явган зорчигчид, унадаг дугуйтай зорчигчид болон тээврийн хэрэгслүүдийг аюулгүй байдлын түвшнээр эрэмбэлэх мөн зорчих хурдаар нь төлөвлөх шаардлагатай;
- Гудамж дахь модны өсөлтийн зай талбайг тооцож төлөвлөх;

6.3. ОЛОН ҮҮРЭГТ ГУДАМЖ

6.3.1. Бүтэц

Олон үүрэгт гудамж нь явган зорчигчид, унадаг дугуйтай зорчигчид, тээврийн хэрэгслээр зорчигчид хамтран орон зайгаа бүрдүүлдэг хурдны удаан зорчилт бүхий гудамж юм. Тус гудамжнууд нь ихэвчлэн орон сууцны хорооллын дотоод орон зайг бүрдүүлсэн байдаг ба худалдааны болон жижиглэн худалдаа, зугаа цэнгэлийн газрууд, ресторан, оффисын, зэрэг төрөл бүрийн зориулалттай газар ашиглалттай байдаг. Бүх төрлийн горимоор зорчигчид гудамжийг хуваалцан ашигладаг боловч явган зорчигчдын хөдөлгөөний зохицуулалт аюулгүй байдлыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай.


1. Явган зорчигч	
2. Дугуйтай зорчигч	
3. Тээврийн хэрэгсэл	

Зураг 9. Олон үүрэгт гудамжны эрэмбэ

6.3.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Тээврийн хэрэгслийн зорчих хурдны хязгаарыг маш бага байлгахаар тооцож төлөвлөх;
- Хөдөлгөөний зохицуулалтыг тэгш хүртээмжтэй байлгахын тулд хүнд оврын ачааны машин нийтийн тээврийн хөдөлгөөнийг хязгаарлаж хувийн унаа, такси, түгээлтийн-мотоцикл гэх мэт овор багатай тээврийн хэрэгслийг хамгийн бага хурдаар зорчих нөхцөлийг дэмжих;
- Явган хүний зам нь шулуун ба ямар нэгэн саадгүй байх, стандартын шаардлага хангасан өргөнтэй, хучилттай байх ба замын хашлага нь замаасаа ялгарахаар төлөвлөгдсөн байх;

- Орон сууцны хорооллын дотоод орон зайд олон үүрэгт гудамж нь оршин суугчдын амралт, чөлөө цагаа өнгөрөөх талбарыг бий болгодог учир тав тухтай тайван, орчныг бүрдүүлсэн байхаар нийтийн эзэмшлийн талбайд гудамжны тохижилтын элементүүдийг анхаарч төлөвлөх;
- Олон төрлийн газар ашиглалттай олон үүрэгт гудамжны орон зайд худалдаа үйлчилгээний үйл ажиллагаа болон уулзалт, арга хэмжээний үйл ажиллагааг дэмжихээр тохижилтын элементүүдийг анхаарч төлөвлөсөн байх;
- Олон үүрэгт гудамжинд борооны ус зайлуулах хоолойг хангалттай хэмжээнд байлгахар төлөвлөсөн байх шаардлагатай.




Зураг 10. Олон үүрэгт гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.4. ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН ГУДАМЖ

6.4.1. Бүтэц

Үйлдвэр аж ахуйн гудамжинд ихэвчлэн хүнд, хөнгөн үйлдвэрийн, дунд болон нам давхаржилттай барилга байгууламжууд, хотын эдийн засгийг дэмжих улсын экспорт импортын бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх томоохон үйлдвэрүүд нь хотын төвөөс зайдуу байршдаг. Мөн явганаар, дугуйгаар, нийтийн тээврийн хэрэгсэл болон хувийн унаагаар зорчих боломжийг тэгш бүрдүүлсэн байх боловч голчлон хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дэмжиж барилгын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах бизнес эрхлэгчдийн ачилт, түгээлтийн хэрэгцээг хангасан байна.



Зураг 11. Үйлдвэр аж ахуйн гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.4.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага


- Хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих эгнээний уулзварын эргэлтийн радиус хангалттай байхаар төлөвлөсөн байх;
- Явган хүний хөдөлгөөний эрчим багатай ч стандартын шаардлага хангасан явган хүний замыг төлөвлөсөн байх;
- Үйлдвэр аж ахуйн гудамжийг төлөвлөхдөө ойр орчмын орон сууцны хорооллын гудамжны замын хөдөлгөөнийг бууруулсан зохицуулалт хийгдсэн байх;
- Энэ төрлийн гудамжинд ногоон байгууламж болон мод тарих тохижилт хийгдэх бол хүрээлэн буй орчин, агаар, ус, хөрсний бохирдуулагч бодисыг шингээх чадвартай ургамлууд ашиглан тохижуулах;

6.5. ХУДАЛДАА АРИЛЖААНЫ ГУДАМЖ

6.5.1. Бүтэц чиг үүрэг

Худалдаа арилжааны гудамжнууд нь ихэвчлэн томоохон худалдааны төв зах дэлгүүрүүд, жижиглэн бөөний худалдаа, оффис, авто үйлчилгээ, хоолны газар бар ресторонууд, барилгын материал тоног төхөөрөмжийн худалдаа үйлчилгээний газрууд, барилгын нүүрэн талыг идэвхтэй ашиглаж буй худалдаа үйлчилгээний зориулалтын барилга байгууламжуудаас бүрдэнэ.

Энэ төрлийн гудамжинд тасралтгүй үргэлжлэх динамик хөдөлгөөн үүсэж замын хөдөлгөөний өндөр ер ачааллыг бий болгодог.



Зураг 12. Худалдаа арилжааны гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.5.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага


- Барилгын арын хэсэгт ачилт, хүргэлт, үйлчилгээ, зогсоолын гэх мэт хэрэгцээгээр нэвтрэх боломжийг ачаалалгүй, саадгүй нэвтрүүлж байхаар төлөвлөх;
- Зэргэлдээх худалдааны болон орон сууцны хорооллын ашиглалтыг дэмжих;
- Хорооллын дотоод холбоос салаа замуудын орох гарах гарц, уулзваруудыг анхаарч төлөвлөх;
- Арилжааны үйл ажиллагааг дэмжих зөвхөн явганаар болон дугуйгаар зорчин үйлчлүүлэх амралт зугаа цэнгэлийн зориулалттай автомашингүй гудамжийг төлөвлөвөл зохимжтой;
- Хүнд даацын тээврийн хэрэгслийн зорчилтыг маш бага байлгах;
- Тус төрлийн гудамжинд өндөр ачаалалтай тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, явган зорчигчид, дугуйтай зорчигчдын ачааллыг тэнцвэржүүлэх бүх төрлийн горимоор гудамж хэрэглэгчдийн тэнцвэрт байдлыг хангах зохицуулалтыг анхаарч үзэх;
- Явган хүний зам нь сайжруулсан өнгөлгөө материалаар хийгдсэн явган зорчигчдын хөдөлгөөний орон зай хангалттай өргөн байхаар төлөвлөх;
- Гэрлэн дохиололгүй гарцын тэмдэг тэмдэглэгээг нүдэнд ил харагдахаар тодорхой байрлуулах, авто замын гарцын өргөтгөлтэй төлөвлөх;

- Гудамжны моддыг төлөв

6.6. СОЁЛЫН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ГУДАМЖ

6.6.1. Бүтэц

Соёлын ач холбогдол бүхий гудамж нь түүхэн болон соёлын шинж чанартай, хотын соёлыг бүрэн илтгэх орчныг бүрдүүлсэн гудамжнууд байна. Ийм төрлийн гудамжинд Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгал, Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий барилга байгууламжийг агуулсан гудамж байна.



Зураг 13. Соёлын ач холбогдол бүхий гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.6.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Тус төрлийн гудамжны барилга байгууламжуудын түүх соёлын өвийг нандигнан хадгалах зорилгоор зөвхөн сэргээн засварлах замаар тохижилт хийх;
- Энэ төрлийн гудамжинд явган хүний хөдөлгөөнийг дэмжиж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж автомашингүй гудамж болгон аялал жуулчлалын гудамж болгож тохижуулбал нэн зохимжтой;
- Гудамжны тохижилтын элементүүдийг нэмэлтээр төлөвлөхдөө түүх, газруудын байршлыг тусгасан тэмдэг тэмдэглэгээг байршуулах, зам талбайн хучилтын материалыг онцгой байлгахаар төлөвлөх;
- Автомашингүй гудамжинд явган зорчигчид нь өдрийн аль ч цагт яаралтай тусламжийн тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжийг олгохоор зай талбайтайгаар төлөвлөх;
- Оршин суугчид, зочид, бизнес эрхлэгчид, явган зорчигчдод ээлтэй талбайг бий болгохоор төлөвлөх;

- Тав тухтай орчныг бүрдүүлж ногоон байгууламжийг орхигдуулахгүй байгалийн ландшафтыг ашиглан тохижуулбал зохимжтой;

6.7. ЦЭЦЭРЛЭГТ ГУДАМЖ

6.7.1. Бүтэц

Тус төрлийн гудамжнууд нь ард иргэдийн амарч зугаалах боломжийг бүрдүүлсэн цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж бүхий үзэсгэлэнт гудамжнууд юм. Эдгээр төрлийн гудамжнууд нь цэцэрлэгт хүрээлэн рүү нэвтрэх боломжийг олгож, цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газрыг дэмжих, нөхөх зорилготой юм. Мөн тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөнд бага зэргийн үүрэг гүйцэтгэдэг боловч явган зорчигч, дугуйтай зорчигчдод чухал үүрэг гүйцэтгэдэг.



Зураг 14. Цэцэрлэгт гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.7.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Цэцэрлэгт хүрээлэнгийн хүрээлэн буй орчин болон байгалийн шинж чанарыг сайжруулж нэмэгдүүлэх, хадгалах, хамгаалах;
- Цэцэрлэгт хүрээлэнгээр дамжин бусад хороолол, гудамжнуудад хүрэх боломжтой таатай нөхцөлтэй явган хүний болон дугуйн замтай байх
- Дугуйн зам болон явган хүний зам нь зорчигчдод аюулгүй байхаар тусдаа төлөвлөгдсөн байвал зохимжтой;
- Одоо байгаа мод ургамал болон борооны ус зайлуулах системийг улам сайжруулж нэмэгдүүлэх;

- Тээврийн хэрэгслийн хурдны зохицуулалтыг тусгаж өгсөн байх;
- Борооны ус зайлуулах байгууламж төлөвлөсөн байх;
- Усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай гэрэлтүүлэг гэх мэт гудамжны тохижилтын элементүүдийг төлөвлөх;


6.8. ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ТӨВ ГУДАМЖ

6.8.1. Бүтэц

Энэ төрлийн гудамж нь нь хот даяар байрлах ба хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс, нам давхрын орон сууцны бүс, дунд давхрын орон сууцны бүс, өндөр давхрын орон сууцны бүсүүдэд орон сууцны хорооллуудаар хүрээлэгдэж хөдөлгөөний эрчимжил ба нягтшил өндөртэй орон сууцны хорооллын гудамжнуудыг бий болгосон байдаг.

Орон сууцны хорооллын гол зам дагуу оршин суугчдын бүх төрлийн хэрэгцээг хангах зориулалттай олон төрлийн худалдаа үйлчилгээ явуулах барилга байгууламжууд (ихэвчлэн орон сууцны барилгын нүүрэн талын хэсэгт өргөтгөл болон ашиглагддаг), өдөр тутмын зайлшгүй хэрэгцээтэй зүйлс банкнаас эхлээд хуурай цэвэрлэгээ хүртэлх үйлчилгээг багтаасан байдаг. Тус төрлийн гудамжнууд нь явган хүний болон дугуйн хөдөлгөөний өндөр түвшин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дунд болон өндөр түвшний хөдөлгөөнийг үүсгэх хотын тээврийн сүлжээний чухал холбоос юм.

Тус төрлийн гудамжнууд нь орон сууцны хорооллуудад нэвтрэх боломжийг олгодог ба оршин суугчдыг тээврийн сүлжээнд холбох, хотын оршин суугчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулах үүрэгтэй.



Зураг 15. Орон сууцны хорооллын төв гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.8.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага


- Барилга байгууламжийн урд хэсгийн зам дээр зорчигч буух хэсгийг онцгой анхаарах (Ялангуяа тээврийн хэрэгслийн зогсоол, буудал)
- Наад зах нь гудамжны аль нэг талд нь машины зогсоолтой байх;
- Том ачаа тээврийн үйлчилгээг багасгах;
- Гудамжны аюулгүй байдлыг хангахын тулд бага моторт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах. Замын хурд сааруулагчийг төлөвлөх;
- Явган хүний хөдөлгөөнийг өндөр түвшинд байлгах үүднээс барилгуудыг явган хүний замын сүлжээтэй холбосон өргөн явган хүний замаар хангах.
- Оршин суугчдын эрүүл аюулгүй тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор гудамж дагуу эгнээ мод тарих(модны өсөлтийг тооцож тарих);

6.9. ХОРООЛЛЫН ДОТООД ХОЛБООС ГУДАМЖ

6.9.1. Бүтэц

Тус төрлийн гудамж нь хорооллын дотоод холбоос гудамжуудыг гол гудамж зам руу нэвтрэх, холбох боломжийг бий болгодог. Явган болон дугуйтай зорчигчдын хөдөлгөөний эрчимжил өндөртэй, тээврийн хэрэгслийн хурдыг сааруулсан, орон сууцны барилга байгууламж, эдэлбэр газар руу хүрэх боломжийг хангасан байдаг.

Энэ төрлийн гудамжинд оршин суугчдын хэрэгцээг хангах бүх төрлийн худалдаа үйлчилгээний зориулалттай үйлчилгээний газрууд, дэлгүүр мини зах худалдааны төвүүд, эмнэлэг эмийн сан, банк, цэцэрлэг гэх мэт барилга байгууламжууд байршина.



Зураг 16.Хорооллын дотоод холбоос гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг


6.9.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Явган болон дугуйтай зорчигч, тээврийн хэрэгслийн уулзвар, гарцыг онцгой анхаарч төлөвлөх;
- Оршин суугчдын аюулгүй байдлыг хангасан байх нөхцөл бололцоог бүрдүүлж хүнд оврын тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бага байлгаж тээврийн хэрэгслийн дуу чимээг үүсгэхгүй байхаар төлөвлөх;
- Оршин суугчдын ая тухтай байдлыг бүрдүүлж ногоон байгууламжийг (мод, өнгө үзэмжтэй цэцэгт ургамал, зүлэг) зайлшгүй төлөвлөх шаардлагатай;
- Гэрэлтүүлэг гэрлэн чимэглэлийг зохих хэмжээгээр стандартын дагуу төлөвлөх;
- Зогсоолуудыг хангалттай төлөвлөх (Дугуйн зогсоол, Машины зогсоол);
- Замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулан төлөвлөх;

6.10. ГЭР ХОРООЛЛЫН ТӨВ ГУДАМЖ

6.10.1. Бүтэц

Тус төрлийн гудамжууд нь нягтрал багатай суурьшлын хэсэг болсон өрхүүдэд зориулсан хашаа байшин, гэр бүхий газар нутгуудаас бүрдэх хотын барилгажсан газар нутгийн 30-аад хувийг эзлэн орших гэр хорооллын бүсийн гол зом дагуух гудамжууд юм. Гэр хорооллын гол гудамжууд нь орон сууц, гэр хороолол, үйлдвэр, үйлчилгээний төвүүдийг хооронд нь холбосон, гэр хорооллын бүсийг хотын төвтэй болон хотын гаднах замтай холбодог. Мөн тэдгээрийг бусад магистраль гудамж замтай холбосон, тээврийн үндсэн хөдөлгөөнийг нэвтрүүлэх гудамж байна.



Зураг 15. Гэр хорооллын төв гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

Энэ төрлийн гудамжнууд нь холимог газар ашиглалттай, хувийн хашаа байшин, дунд давхаржилттай орон сууцны хорооллууд, худалдаа үйлчилгээний зориулалттай барилга байгууламжууд, оршин суугчдын бүх төрлийн хэрэгцээг хангах авто засварын газраас сургууль, цэцэрлэг банк хүртэлх барилга байгууламжууд байршина.

6.10.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Улаанбаатар хотыг 2020 оны хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад тусгаснаар төвийн бүсийн гэр хорооллыг өндөр дунд давхрын орон сууцны хороолол, дундын бүсийн гэр хорооллыг дунд нам давхрын орон сууцны хороолол, захын бүсийн гэр хорооллыг сайжруулсан гэр сууцны хороолол байхаар төлөвлөнө;
- Гэрэлтүүлэг гэрлэн чимэглэл, камержуулалттай байх;
- Хотын чанартай авто зам, явган хүний зам, дугуйн замтай байх;
- Хашаа хайс нь өнгө үзэмжтэй стандартын дагуу тохижуулсан байх;
- Оршин суугчдын эрүүл аюулгүй тав тухтай байдлыг бүрдүүлэх зорилгоор ногоон байгууламж цэцэрлэгт гудамжны тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар төлөвлөх;
- Гол гудамж дагуу гудамжны хоёр талаар мод тарьж цэцэрлэгжүүлэх;
- Бусад авто зам руу орох нөхцөлөөр хангагдсан гарцтай байна;
- Ногоон химид суурилсан, цэвэршүүлэх, хаягдалгүй, технологийн хөтөлбөрт арга ажиллагааг хэрэгжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдлыг арилгах, хохирлыг багасгах замаар төлөвлөх;
- Өндөр технологийн бие даасан болон хэсэгчилсэн дэд бүтцийг хөхүүлэн дэмжих замаар хөгжүүлэх;

6.11. ГЭР ХОРООЛЛЫН ДОТООД ХОЛБООС ГУДАМЖ

6.11.1. Бүтэц

Энэ төрлийн гудамжнууд нь гэр хорооллын тээврийн хэрэгслийн болон явган зорчигчдын хөдөлгөөнийг гол гудамж зам руу нэвтрүүлэх, хороолол хоорондын тасралтгүй хөдөлгөөнийг бий болгох, орон сууцны барилга, байгууламж, эдэлбэр газар руу орох, хүрэх боломжийг хангасан гудамжнууд байна. Эдгээр гудамжнуудад хувийн хашаа байшин, амины сууц, жижиглэн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга байгууламжуудаас бүрдэж гэр хорооллын дотоод холбоос гудамжнуудыг бүрдүүлж байна.

6.11.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Нэн тэргүүнд оршин суугчдын эрүүл аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гэрэлтүүлэг камержуулалттай байх;
- Хашаа хайс нь өнгө үзэмжтэй бөгөөд эмх цэгцтэй байх;

- Явган хүний зам дугуйн зам авто зам нь хүртээмжээсээ хамаарч сайжруулсан шороон зам болон байгалийн чулуун замыг ашиглан тохижилт хийгдсэн байж болно;
- Гудамжны цэвэрлэгээ үйлчилгээг орхигдуулахгүй байх;
- Хотын амьдралын нөхцөл стандартыг бүрэн хангасан өвөрмөц, монгол дүр төрх бүхий сайжруулсан гэр сууцны хороолол бүхий гудамж байх;
- Оршин суугчдын ая тухтай, орчны аюулгүй байдлыг бүрдүүлсэн байх, Агаарын бохирдол тоосжилтыг багасгах зорилгоор ногоон байгууламжийн тоо хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт гудамжны тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар төлөвлөх;
- Гудамжны тэмдэг тэмдэглэгээний самбар, гудамжны нэршлийн самбарыг байршуулсан байх;
- Гэр хорооллын гудамж дагуух цахилгааны шонг анхаарч төлөвлөх;
- Үерийн далан, борооны ус зайлуулах систем төлөвлөх;
- Явган болон дугуйтай зорчигчдын аюулгүй байдлыг чухалчилж гудамжны гарц уулзвар, эргэлтийг онцгой анхаарч төлөвлөх;




Зураг 17. Гэр хорооллын дотоод холбоос гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.12. НАРИЙН ГУДАМЖ

6.12.1. Бүтэц

Тус төрлийн гудамж нь бусад төрлийн гудамжнаас зай талбай багатай нарийхан гудамжнууд юм. Нарийн гудамж нь явган зорчигчийг гол гудамж зам руу нэвтрэх, граж автомашины зогсоолоос тэврийн сүлжээнд нэвтрэх орон зайг бий болгон үүссэн байдаг ба ихэвчлэн барилгын хажуу арын хэсгийн эгнээгээр, гэр хорооллын гудамжнуудад,

хашаа хооронд, орон сууцны хороолол хооронд, худалдаа үйлчилгээний газрын ачих буулгах зай талбайд, сургууль цэцэрлэгийн бүс рүү нэвтрэх нарийн гудамж замуудаар үүсэн бий болсон байна.



Зураг 18. Нарийн гудамжны тохижилт, төлөвлөлтийн жишээ зураг

6.12.2. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага

- Нарийн гудамжнууд нь ихэвчлэн төлөвлөлтөд төдийлөн тусгагдаагүй орхигдсон байдаг ба гэрэлтүүлэг, камержуулалт муутай асуудлуудаас гэмт хэрэг гарах магадлал өндөр байдаг тул тус төрлийн гудамжнуудад явган зорчигчийн аюулгүй байдлыг чухалчилж гэрэлтүүлэг, камержуулалт төлөвлөх шаардлагатай;
- Явган хүний зам, дугуйн замыг зай талбайд нь зохистой хэмжээгээр стандартын дагуу төлөвлөх;
- Хэрэв тээврийн хэрэгсэл нэвтрэх эрхтэй бол хөдөлгөөний хурдыг 10 км / цаг хүртэл хязгаартай байх;
- Худалдаа арилжаа бүхий нарийн гудамж дагуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор барилга байгууламжийн доод давхрыг ашиглан үйл ажиллагаа явуулахаар тохижуулах;
- Явган алхах саадыг бүрдүүлсэн илүүдэл гудамжны элементүүдийг төлөвлөхгүй байх;
- Гудамжны ханын зургуудыг ашиглан төлөвлөвөл зохимжтой;
- Гудамжны цэвэрлэгээ үйлчилгээг орхигдуулахгүй байх;
- Замын хөдөлгөөн ихтэй гарц уулзваруудыг анхаарч төлөвлөх;

7. ШАЛГАХ ХУУДАС

Гудамжны тохижилт бүтээн байгуулалт хийх, зураг төсөл боловсруулах төлөвлөхдөө тухайн гудамжны төрөл ангилалд тохирсон төлөвлөлт хийх шаардлагатай.

Хүснэгт 1. Хотын гол гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Явган хүний зам, өргөн чөлөө нь өргөн болоод өндөр чанартай байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гудамжны элементүүдийг бүрэн төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Явган зорчигчид, унадаг дугуйтай зорчигчид болон тээврийн хэрэгслүүдийг аюулгүй байдлын түвшнээр эрэмбэлэн, зорчих хурдны хязгаарыг заасан байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гудамж замын уулзварын тэмдэг тэмдэглэгээ нь товч тодорхой нүдэнд тусахуйц төлөвлөгдсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Барилга байгууламжийн урд хэсэгт дугуйн зогсоол төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гудамж дахь модны өсөлтийн зай талбайг тооцож төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хотын гол гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 2. Өргөн чөлөө бүхий гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Стандартын шаардлага хангасан авто зам, явган хүний зам, дугуйн замтай байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Өргөн чөлөө нь өргөн бөгөөд өндөр чанартай байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Гудамжны блокийн уртын дагуу тохижилт хийгдсэн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гудамжны элементүүдийг бүрэн төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гудамж дахь модны өсөлтийн зай талбайг тооцож төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гудамж замын уулзварын тэмдэг тэмдэглэгээ нь товч тодорхой нүдэнд тусахуйц төлөвлөгдсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Өргөн чөлөө бүхий гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 3. Олон үүрэгт гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Тээврийн хэрэгслийн зорчилтын хурдны хязгаарыг маш бага хурдтай байлгах;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хүнд оврын ачааны машин хөдөлгөөнийг хязгаарлах;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Явган хүний зам нь шулуун ба ямар нэгэн саадгүй байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Нийтийн эзэмшлийн талбайд гудамжны тохижилтын элементүүдийг нэн тэргүүнд явган зорчигчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн анхаарч төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Борооны ус зайлуулах хоолойг хангалттай хэмжээнд байлгахгаар төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Олон үүрэгт гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 4. Аж үйлдвэрийн гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих эгнээний уулзварын эргэлтийн радиус хангалттай байхаар төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Стандартын шаардлага хангасан явган хүний замыг төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Ойр орчмын орон сууцны хорооллын гудмын замын хөдөлгөөнийг бууруулсан зохицуулалт хийгдсэн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Ногоон байгууламж болон мод тарих тохижилт хийгдэх бол хүрээлэн буй орчин, агаар, ус, хөрсний бохирдуулагч бодисыг шингээх чадвартай ургамлууд ашиглан тохижуулсан байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гарц уулзварыг төлөвлөхдөө хангалттай зай хэмжээтэйгээр төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Аж үйлдвэрийн гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 5. Худалдаа арилжааны гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
---	------------------	------	------

1	Гэрлэн дохиололгүй гарцын тэмдэг тэмдэглэгээг нүдэнд ил харагдахаар тодорхой байрлуулах, авто замын гарцын өргөтгөлтэй төлөвлөгдсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Барилгын арын хэсэгт ачилт, хүргэлт, үйлчилгээ, зогсоолын гэх мэт хэрэгцээгээр нэвтрэх боломжийг ачаалалгүй, саадгүй нэвтрүүлж байхаар төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Явган хүний зам нь сайжруулсан өнгөлгөө материалаар хийгдсэн явган зорчигчдын хөдөлгөөний орон зай хангалттай өргөн байхаар төлөвлөх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Зэргэлдээх худалдааны болон орон сууцны хорооллын ашиглалтыг дэмжихээр төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ногоон байгууламжийн төлөвлөлт хийгдсэн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Худалдаа арилжааны гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 6. Соёлын ач холбогдол бүхий гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гудамжны тохижилтын элементүүдийг нэмэлтээр төлөвлөхдөө түүх, соёлын дурсгалт газруудыг тусгасан тэмдэг тэмдэглэгээг байршуулах, зам талбайн хучилтын материалыг онцгой байлгахаар төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хотын түүх соёлын шинж чанар бүхий орчныг бүрдүүлсэн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Барилга байгууламжуудын түүх соёлын өвийг нандигнан хадгалах зорилгоор зөвхөн сэргээн засварлах замаар барилгын тохижилтыг хийсэн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Тус төрлийн гудамжинд явган хүний хөдөлгөөнийг дэмжиж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж автомашингүй гудамж болгон аялал жуулчлалын гудамж болгож тохижуулбал нэн зохимжтой;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Автомашингүй гудамжинд явган зорчигчид нь өдрийн аль ч цагт яаралтай тусламжийн тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжийг олгохоор зай талбайтайгаар төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Оршин суугчид, зочид, бизнес эрхлэгчид, явган зорчигчдод ээлтэй талбайг бий болгохоор төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

7	Тав тухтай орчныг бүрдүүлж ногоон байгууламж төлөвлөгдсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
---	---	--------------------------	--------------------------

Тайлбар: Соёлын ач холбогдол бүхий гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 7. Цэцэрлэгт гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Дугуйн зам болон явган хүний зам нь зорчигчдод аюулгүй байхаар тусдаа төлөвлөгдсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Тээврийн хэрэгслийн хурдны зохицуулалтыг тусгаж өгсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Борооны ус зайлуулах байгууламж төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай гэрэлтүүлэг гэх мэт гудамжны тохижилтын элементүүдийг стандартын дагуу төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Олон төрлийн цэцэгт ургамлыг төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Цэцэрлэгт гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 8. Хөршлөл бүхий орон сууцны хорооллын төв гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Барилга байгууламжийн урд хэсгийн зам дээр зорчигч буух хэсгийг онцгой анхаарч төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Наад зах нь гудамжны аль нэг талд нь машины зогсоолтой байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Замын хурд сааруулагчийг төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Явган хүний хөдөлгөөнийг өндөр түвшинд байлгах үүднээс барилгуудыг явган хүний замын сүлжээтэй холбосон өргөн явган хүний замтай төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Оршин суугчдын эрүүл аюулгүй тухтай орчныг бүрдүүлэх тохижилт хийгдсэн байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гудамжны элементүүдийг стандартын шаардлага хангахуйц төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хөршлөл бүхий орон сууцны хорооллын төв гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 9. Хорооллын дотоод холбоос гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Явган болон дугуйтай зорчигч, тээврийн хэрэгслийн уулзвар, гарцыг онцгой анхаарч төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гэрэлтүүлэг гэрлэн чимэглэлийг зохих хэмжээгээр стандартын дагуу төлөвлөсөн байх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Зогсоолуудыг хангалттай төлөвлөх (Дугуйн зогсоол, Машины зогсоол);	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулан төлөвлөх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Чиглүүлэгч самбартай байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хорооллын дотоод холбоос гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 10. Гэр хорооллын төв гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гэрэлтүүлэг гэрлэн чимэглэл, камержуулалттай эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хотын чанартай авто зам, явган хүний зам, дугуйн замтай эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хашаа хайс нь өнгө үзэмжтэй стандартын дагуу тохижуулсан эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гол гудамж дагуу шаардлагатай хэсэгт мод тарьж цэцэрлэгжүүлсэн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Өндөр технологийн бие даасан болон хэсэгчилсэн дэд бүтцийг дэмжих замаар хөгжүүлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гудамжны элементүүдийг төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Гэр хорооллын төв гудамжны төрөл нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 11. Гэр хорооллын дотоод холбоос гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гэрэлтүүлэг камержуулалттай эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хашаа хайс нь өнгө үзэмжтэй бөгөөд эмх цэгцтэй эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

3	Хотын амьдралын нөхцөл стандартыг бүрэн хангасан өвөрмөц, монгол дүр төрх бүхий тохижилт хийгдсэн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гудамжны тэмдэг тэмдэглэгээний самбар, гудамжны нэршлийн самбарыг байршуулсан эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Үерийн далан, борооны ус зайлуулах систем төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Гэр хорооллын дотоод холбоос гудамжны төрөл ангилал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт 12. Нарийн гудамжны шалгах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Явган хүний зам, дугуйн замыг зай талбайд нь зохистой хэмжээгээр стандартын дагуу төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Явган алхах саадыг бүрдүүлсэн илүүдэл гудамжны элементүүдийг төлөвлөөгүй эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Гудамжны ханын зургуудыг ашиглан төлөвлөсөн эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гэрэлтүүлэг камержуулалттай эсэх;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Нарийн гудамжны төрөл ангилал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 30-01-04 “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- UCS0901В:2020 “Явган хүний зам талбайн төлөвлөлт угсралтад тавигдах шаардлага”
- UCS0903В:2020 “Унадаг дугуйн замын төлөвлөлт хучилтад тавигдах шаардлага”
- Улаанбаатар хотыг 2020 оны хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага;
- Хотуудын тээврийн албаны үндэсний холбоо, 2016 он; /“Global street design guide”, NACTO 2016/
- Торонто хотын иж бүрэн гудамжны баримт бичиг 2017 он; /“Toronto complete street design guidelines” 2017/;
- Аукланд хотын гудамж, замын зураг төсөл боловсруулах гарын авлага, 2019 он; /Auckland “Urban Street and Road Design Guide”, 2019/